



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

Техникийн зохицуулалт батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 6.5, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

1174 1206 9023100394 5498449

Засгийн газрын 2024 оны 06 дугаар
сарын 06-ны өдрийн 253 дугаар
тогтоолын хавсралт

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ТАВИХ
ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Зорилго, хамрах хүрээ

1.1.1.Энэ техникийн зохицуулалт нь Дээд боловсролын тухай хуулийн 6.1, 7.4-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны хүрээ, сургалт, судалгааны чиглэл, холбогдох бусад үзүүлэлтэд суурилан ангилах шалгуур үзүүлэлтийг тогтоох үйл ажиллагааг зохицуулна.

1.1.2.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 5.2-т зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа дээд боловсролын сургалтын байгууллага энэ техникийн зохицуулалтыг заавал дагаж мөрдөнө.

1.2.Норматив эшлэл

1.2.1.Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн дараах хууль, стандарт, баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийг хэвлэсэн хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс эш татаж хэрэглэнэ:

1.2.1.1.Боловсролын ерөнхий хууль;

1.2.1.2.Дээд боловсролын тухай хууль;

1.2.1.3.Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль;

1.2.1.4.Зөвшөөрлийн тухай хууль;

1.2.1.5.Хөдөлмөрийн тухай хууль;

1.2.1.6.Зөрчлийн тухай хууль;

1.2.1.7.Төрийн хяналт шалгалтын тухай хууль;

1.2.1.8.Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт;

1.2.1.9.Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт;

1.2.1.10.MNS 5742:2019 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага;

1.2.1.11.MNS 4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага;

1.2.1.12.MNS 5869:2008 Оюутны дотуур байрны үйлчилгээ. Ерөнхий шаардлага;

1.2.1.13.MNS 6929-2:2021 Байгууллагын архивын өрөө, хадгаламжийн санд тавих шаардлага;

1.2.1.14.Олон нийт иргэний барилга БНБД31-03-03;

1.2.1.15.Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх БНБД31-23-22;

1.2.1.16.Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийг зураг, төсөл боловсруулах норм, дүрэм, БНБД II 66-888;

1.2.1.17.MNS0900:2018 Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарт;

1.2.1.18.Боловсролын олон улсын стандарт ангилал 2013;

1.2.1.19.Боловсролын олон улсын стандарт ангилал 2013-F;

1.2.1.20.Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталсан “Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт”;

1.2.1.21.Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс”;

1.2.1.22.Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталсан “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”;

1.2.1.23.Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”;

1.2.1.24.Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”;

1.2.1.25.Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/821/128 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж, тохируулах журам”;

1.2.1.26.Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”.

1.3.Нэр томьёо, тодорхойлолт

1.3.1.Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.1.“Их сургууль” гэж Дээд боловсролын тухай хуулийн 7.1-д заасныг;

1.3.1.2.“Судалгааны их сургууль” гэж Дээд боловсролын тухай хуулийн 4.1.4-т заасныг;

1.3.1.3.“Сургалтын их сургууль” гэж хэд хэдэн мэргэжлийн чиглэлээр сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг, шинжлэх ухааны тодорхой чиглэлүүдээр судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг дээд боловсролын сургалтын байгууллагыг;

1.3.1.4.“Мэргэжлийн их сургууль” гэж нийт суралцагчийн дийлэнх олонх нэг мэргэжлийн чиглэлээр суралцдаг, тухайн чиглэлээр судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг дээд боловсролын сургалтын байгууллагыг;

1.3.1.5.“Коллеж” гэж Дээд боловсролын тухай хуулийн 9.1-д заасныг.

Хоёр.Их сургууль, коллежид тавих
нийтлэг шаардлага

2.1.Их сургууль, коллеж дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

2.1.1.сургалтын зориулалт бүхий өөрийн эзэмшлийн газартай байх;

2.1.2.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;

2.1.3.байгууллагын магадлан итгэмжлэлийн хугацаа хүчин төгөлдөр байх;

2.1.4.“Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт”, “Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-д тус тус нийцсэн дараах шаардлагыг хангасан байх:

2.1.4.1.барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулсан;

2.1.4.2.“MNS 5869:2008 Оюутны дотуур байрны үйлчилгээ. Ерөнхий шаардлага”-ыг хангасан оюутны дотуур байртай байна. Дотуур байргүй тохиолдолд дотуур байраар хангагдах шаардлагатай суралцагчдыг стандартын шаардлага хангасан байгууллагуудтай гэрээ байгуулж, байраар хангасан;

2.1.4.3.Суралцагчийн тоо сургуулийн хүчин чадалд тохирсон байна. Нийт суралцагчийн тоог сургалтын танхим, лабораторийн нийт суудлын тоонд харьцуулж тодорхойлсон ээлж ашиглалтын коэффициент хоёр ба түүнээс бага;

2.1.4.4.Суралцагчийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх биеийн тамирын заал, талбайтай байхыг шаардана. Биеийн тамирын заал, талбайгүй тохиолдолд холбогдох байгууллагатай гэрээ байгуулж, сургалт эрхэлдэг;

2.1.4.5.“MNS 4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага”-ыг хангасан хоолны газартай;

2.1.4.6.“MNS 5742:2019 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага”-ыг хангасан номын сантай.

2.1.5.хөтөлбөр бүрээр суралцагчид хүрэлцэхүйц тооны мэргэжлийн ном, сурах бичигтэй байх;

2.1.6.Дээд боловсролын тухай хуулийн 15.1, 15.2-г заасан боловсролын зэрэгтэй багш сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг байх;

2.1.7.дараах шаардлагыг хангасан үндсэн багш, суралцагчийн харьцаа (сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа багш, суралцагчийн тоогоор тодорхойлох)-тай байх:

2.1.7.1.сургуулийн нийлбэр дүнгээр нэг үндсэн багшид ногдох суралцагчийн тоо 30 хүртэл (орон нутгийн салбар болон харьяа сургуулийг тусад нь тооцно) байна;

2.1.7.2.зөвхөн дэд бакалаврын, эсвэл бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлдэг бол 30 оюутан тутамд нэг мэргэжлийн багш байна;

2.1.7.3.ижил нэр, индекс бүхий дэд бакалавр болон бакалаврын хөтөлбөрийг зэрэг хэрэгжүүлдэг бол 210 хүртэлх суралцагчдад таваас багагүй мэргэжлийн багш шаардана;

2.1.7.4.зөвхөн магистрын түвшний хөтөлбөр хэрэгжүүлдэг бол тухайн хөтөлбөрийн 15 магистрант тутамд докторын зэрэгтэй тухайн мэргэжлийн нэг багш шаардана;

2.1.7.5.ижил нэр, индекс бүхий бакалавр ба магистрын хөтөлбөрийг зэрэг хэрэгжүүлдэг бол бакалаврын 120 хүртэл бөгөөд магистрын 30 хүртэл суралцагчид нийт таваас багагүй мэргэжлийн багш шаардана. Нийт шаардах багшийн 40-өөс багагүй хувь нь докторын зэрэгтэй байна;

2.1.7.6.зөвхөн докторын түвшний хөтөлбөр хэрэгжүүлдэг бол тухайн хөтөлбөрийн 5 докторант тутамд докторын зэрэгтэй мэргэжлийн нэг багш шаардана;

2.1.7.7.ижил нэр, индекс бүхий магистр, докторын хөтөлбөрийг хамт хэрэгжүүлдэг бол нийт 30 хүртэл суралцагчдад гурваас багагүй докторын зэрэгтэй мэргэжлийн багш шаардана;

2.1.7.8.ижил нэр, индекс бүхий дэд бакалавр, бакалавр, магистрын хөтөлбөрийг зэрэг хэрэгжүүлдэг бол дэд бакалавр ба бакалаврын нийт 210 хүртэл, магистрын 15 хүртэл суралцагчдад мэргэжлийн багш зургаагаас багагүй байна. Үүнээс 30-аас багагүй хувь нь докторын зэрэгтэй байна;

2.1.7.9.ижил нэр, индекс бүхий бакалавр, магистр, докторын хөтөлбөрийг зэрэг хэрэгжүүлдэг бол бакалаврын 120 хүртэл, магистрын 15, докторын 10 хүртэл суралцагчдад мэргэжлийн багш зургаагаас багагүй байна. Үүнээс 40-өөс багагүй хувь нь докторын зэрэгтэй байна;

2.1.7.10. ижил нэр, индекс бүхий дэд бакалавр, бакалавр, магистр, докторын хөтөлбөрийг зэрэг хэрэгжүүлдэг бол дэд бакалавр болон бакалаврын 210 хүртэл, магистрын 15, докторын 10 хүртэл суралцагчдад мэргэжлийн багш наймаас багагүй байна. Үүнээс 30-аас багагүй хувь нь докторын зэрэгтэй байна;

2.1.7.11. энэ техникийн зохицуулалтын 2.1.7.2-2.1.7.10-д заасан үндсэн багшийн тоо дэд бакалавр ба бакалаврын хөтөлбөрийн хувьд 30 оюутнаар тооцсон нэг бүлэг нэмэгдэхэд мэргэжлийн нэг багш нэмж шаардана. Магистрын 15 эсвэл докторын 10 суралцагч бүхий нэг бүлэг нэмэгдэхэд нэг докторын зэрэгтэй мэргэжлийн багш нэмж шаардана.

2.1.8. Гэрээт, зөвлөх, цагийн багшаар заалгах хичээлийн хэмжээ тухайн хөтөлбөрийн нийт агуулгыг 20 хувиас хэтрэхгүй байх;

2.1.9. MNS 6929-2:2021 Байгууллагын архивын өрөө, хадгаламжийн санд тавих шаардлагыг хангасан архивын өрөөтэй, ажил хариуцсан мэргэжлийн ажилтантай байх;

2.1.10. Сургуулийн удирдлагын мэдээллийн системтэй байх.

Гурав. Их сургуульд тавигдах тусгай шаардлага

3.1. Судалгааны их сургууль дараах тусгай шаардлага, түүнээс 2, 3, 4, 5, 6, 7 дугаар шалгуурыг заавал хангасан байна:

№	Шаардлага	Тооцох хугацаа	Үзүүлэлт
1.	Ахисан түвшний суралцагчийн эзлэх хувь	3 жилийн дунджаар	≥30
2.	Докторын зэрэгтэй үндсэн багшийн эзлэх хувь		≥50
3.	h-индексстэй үндсэн багшийн эзлэх хувь		≥20
4.	Докторын зэрэг хамгаалуулсан төгсөгчийн тоо	3 жилийн нийлбэр дүнгээр	≥50
5.	Олон улсын эрдэм шинжилгээний бүтээлийн санд бүртгэлтэй бүтээлийн тоо		≥200
6.	Нэг багшид ногдох эрдэм шинжилгээний ажилд зарцуулж буй зардал (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлэн тооцсон)	санхүүгийн 3 жилийн дунджаар	х8
7.	Нэг багшид ногдох эрдэм шинжилгээ, судалгааны орлого* (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлэн тооцсон)		х5
8.	Нийт орлогод судалгааны ажлын орлогын эзлэх хувь		≥30

3.2. Сургалтын их сургууль дараах тусгай шаардлага, түүнээс 1, 3, 4, 7, 9 дүгээр шалгуурыг заавал хангасан байна:

№	Шаардлага	Тооцох хугацаа	Үзүүлэлт
1.	Докторын зэрэг олгох хөтөлбөрийн тоо	сүүлийн хичээлийн жилд	≥2
2.	Магистрын зэрэг олгох хөтөлбөрийн тоо		≥5
3.	Ахисан түвшний суралцагчийн эзлэх хувь	3 жилийн дунджаар	≥20
4.	Докторын зэрэгтэй үндсэн багшийн эзлэх хувь		≥40
5.	h-индексстэй үндсэн багшийн эзлэх хувь		≥10

6.	Докторын зэрэг хамгаалуулсан төгсөгчийн тоо	3 жилийн нийлбэр дүнгээр	≥ 9
7.	Олон улсын эрдэм шинжилгээний бүтээлийн санд бүртгэлтэй бүтээлийн тоо		≥ 15
8.	Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн дотоодын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо		≥ 60
9.	Нэг багшид ногдох эрдэм шинжилгээний ажилд зарцуулж буй зардал* (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлэн тооцсон)	санхүүгийн 3 жилийн дунджаар	x5
10.	Нэг багшид ногдох эрдэм шинжилгээ, судалгааны орлого (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлэн тооцсон)		x3

3.3.Мэргэжлийн их сургууль дараах тусгай шаардлага, түүнээс 1, 3, 5, 10 дугаар шалгуурыг заавал хангасан байна:

№	Шаардлага	Тооцох хугацаа	Үзүүлэлт
1.	Докторын зэрэг олгох хөтөлбөрийн тоо	сүүлийн	≥1
2.	Магистрын зэрэг олгох хөтөлбөрийн тоо	хичээлийн	≥2
3.	ШУ-ны нэг чиглэл дагнасан хөтөлбөрийн эзлэх хувь	жилд	≥60
4.	Ахисан түвшний суралцагчийн эзлэх хувь	3 жилийн дунджаар	≥10
5.	Докторын зэрэгтэй үндсэн багшийн эзлэх хувь		≥30
6.	h-индекстэй үндсэн багшийн эзлэх хувь		≥5
7.	Докторын зэрэг хамгаалуулсан төгсөгчийн тоо	3 жилийн нийлбэр дүнгээр	≥3
8.	Олон улсын эрдэм шинжилгээний бүтээлийн санд бүртгэлтэй бүтээлийн тоо		≥10
9.	Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн дотоодын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо		≥30
10.	Нэг багшид ногдох эрдэм шинжилгээний ажилд зарцуулж буй зардал* (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлэн тооцсон)	санхүүгийн 3 жилийн дунджаар	x1

3.4.Төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг, улсын стратегийн онцгой салбар болон үндэсний өв соёл, шашны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагыг мэргэжлийн их сургуулийн ангилалд хамааруулах бөгөөд дараах үзүүлэлтийг тусгайлан авч үзнэ:

3.4.1.шинжлэх ухааны нэг чиглэл дагнасан хөтөлбөрийн эзлэх хувь 75 ба түүнээс их байна;

3.4.2.ахисан түвшний суралцагчийн эзлэх хувь 5 ба түүнээс их байна;

3.4.3.докторын зэрэг хамгаалуулсан төгсөгчийн тоо 1 ба түүнээс их байна;

3.4.4.Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн дотоодын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо 20 ба түүнээс их байна.

Дөрөв.Коллежид тавих тусгай шаардлага

4.1.Коллеж дараах тусгай шаардлага, түүнээс 2, 3 дугаар тусгай шалгуурыг заавал хангасан байна:

№	Шаардлага	Тооцох хугацаа	Үзүүлэлт
1.	Магистрын зэрэг олгох хөтөлбөрийн тоо	сүүлийн хичээлийн жилд	≥ 1
2.	Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн тоо		≥ 5
3.	Докторын зэрэгтэй үндсэн багшийн эзлэх хувь	3 жилийн дунджаар	≥ 15

4.2. Дээд боловсролын зэргийн сургалтын хөтөлбөрийн суралцагчийн тоо 600-аас багагүй тохиолдолд бакалаврын хөтөлбөрийн тоо таваас доош байж болно.

Тав. Ангилал тогтоох үйл ажиллагаа

5.1. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг 4 жил тутам шинэчлэн тогтооно.

5.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тогтооход боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дээд боловсрол, санхүү, хяналт-шинжилгээ, үнэлгээ, эрх зүйгээр мэргэшсэн шинжээч, мэргэжилтэн, улсын байцаагч, оюутны байгууллага, мэргэжлийн зөвлөл, холбоо, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл бүхий шинжээчдийн Ажлын хэсэг томилж ажиллуулна.

5.3. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ажлын удирдамжийн дагуу шинжээчдийн Ажлын хэсэг Дээд боловсролын тухай хуулийн 12.13-т заасан цахим сангийн мэдээлэл, бусад нотлох баримтын дагуу үзлэг хийж, "бүрэн хангасан", "хангасан", "хангаагүй" гэсэн дүгнэлт гаргана.

5.4. Шинжээчдийн Ажлын хэсэг гаргасан дүгнэлтээ Дээд боловсролын тухай хуулийн 2.5.1-д заасан Дээд боловсролын зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

5.5. Шинжээчдийн Ажлын хэсгийн дүгнэлт болон Дээд боловсролын зөвлөлийн хурлын тэмдэглэлд үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эцсийн шийдвэр гаргана.

5.6. Шинээр сургууль үүсгэн байгуулах болон ангилал өөрчлөх тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ангилал тогтоох хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ. Шинээр сургууль үүсгэн байгуулах тохиолдолд энэ техникийн зохицуулалтын 2.1.2, 2.1.3-т заасан шаардлагыг шаардахгүй.

5.7. Дээд боловсролын сургалтын байгууллага тухайн ангилалд тавих нийтлэг болон нийт тусгай шаардлагын 90 ба түүнээс дээш хувийг биелүүлсэн бол "бүрэн хангасан" гэж үзнэ.

5.8. Их сургуульд тавих шаардлагыг бүрэн хангаагүй ч нийтлэг шаардлагын 2.1.3, 2.1.4.3, 2.1.5-2.1.7, 2.1.10-д заасан шаардлага, судалгааны, сургалтын, эсвэл мэргэжлийн их сургуульд тавих тусгай шаардлагын 80 хувийг биелүүлсэн бол тухайн ангиллын шаардлагыг "хангасан" гэж үзнэ.

5.9. Коллежид тавих шаардлагыг бүрэн хангаагүй ч нийтлэг шаардлагын 2.1.3, 2.1.4.3, 2.1.5, 2.1.6, 2.1.7, 2.1.10-д заасан шаардлага, коллежид тавих тусгай

шаардлагын 2, 3 дугаар тусгай шалгуурыг заавал биелүүлсэн бол тухайн ангиллын шаардлагыг "хангасан" гэж үзнэ.

5.10.Энэ техникийн зохицуулалтын 5.8, 5.9-д заасан нөхцөлөөр тухайн ангиллын шаардлагыг хангаагүй дээд боловсролын сургалтын байгууллагыг "хангаагүй" гэж үзнэ.

5.11."Хангасан" дүгнэлт авсан дээд боловсролын сургалтын байгууллага тухайн ангиллын шаардлагыг 2-4 жилийн хугацаанд бүрэн хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.12.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ техникийн зохицуулалтын дагуу аль ч ангиллын шаардлагыг хангаагүй дээд боловсролын сургалтын байгууллагын талаар холбогдох шийдвэрийг эрх бүхий байгууллагын дүгнэлтэд үндэслэн гаргана.

5.13.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналт шалгалтын дүнгээр ангиллын шаардлагыг хангахгүй байгаа нь нотлогдсон бол тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр бууруулж болно.

5.14.Дээд боловсролын сургалтын байгууллага ангилал тогтоолгох үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтээ боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.